



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/046/НА-СТА-ОНӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegia@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Баттоогоо
Утас: 325093 Цахим хаяг: battagoon@audit.gov.mn

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
БХУСАТ	Багахангай Ус суваг ашиглалтын товчоо
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗУХА	Зөөврийн ус хангамжийн алба
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МТАН	Мэдээлэл технологи автоматжуулалтын алба
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХСУХАТАҮЗЗ	Хот суурины ус хангамж, ариутгах, татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03.14 № 01/235
танай _____-ны № _____-г

УЛААНБААТАР ХОТЫ УС
СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Ц.ТӨРХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn системд ил тодоор байршуулаагүй, хөрөнгийн дансанд орлого авч бүртгээгүй, үнийн дүн тодорхойгүй 210 ширхэг үндсэн хөрөнгүүд байна.

Аудитын гол асуудал

Тус ОНӨААТҮГ нь 2024 оны зорилтот түвшинд орлогыг үндсэн үйл ажиллагаанаас 127,144.4 сая төгрөг, үйл ажиллагааны бус үйл ажиллагаанаас 3,311.2 сая төгрөг, нийт 130,455.6 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр нийт 142,268.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 9.1 хувиар давуулан биелүүлсэн нь ашигт ажиллагаанд нөлөөлж, татварын дараах цэвэр ашиг 6,307.3 сая төгрөгт хүрсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

C:\Users\seidram.d\OneDrive\2025\Word\Yuan hiong\2025 03 15\USLO.docx

1425010258

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	59,363,021,102.33	87,730,780,102.30
1.1.2	Дансны авлага	11,186,108,377.96	9,885,814,586.78
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,499,302,175.93	1,473,738,911.99
1.1.4	Бусад авлага	6,806,092.36	41,846,566.35
1.1.6	Бараа материал	15,061,291,404.28	13,018,966,779.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	294,162,542.82	399,745,111.05
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	87,410,691,695.68	112,550,892,057.57
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	290,096,302,892.59	274,493,676,875.02
1.2.2	Биет бус хөрөнгө	112,476,851,903.31	113,077,871,785.53
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	13,975,500.00	22,190,750.95
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	402,587,130,295.90	387,593,739,411.50
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	489,997,821,991.58	500,144,631,469.07
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	749,405,699.29	525,830,140.15
2.1.1.2	Цалингийн өглөг		460,045,773.00
2.1.1.3	Татварын өр	39,349,020.65	2,354,579,073.86
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	848,200,002.18	967,282,878.24
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	140,577,282.45	704,770,535.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,777,532,004.57	5,012,508,400.25
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	109,349,788.01	125,226,905.40
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	109,349,788.01	125,226,905.40
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,886,881,792.58	5,137,735,305.65
	Эздийн өмч		
2.3	Өмч:	874,877,566.30	874,877,566.30
2.3.1	-төрийн	874,877,566.30	874,877,566.30
2.3.2	-хувийн		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	111,919,323,994.14	111,788,353,550.49
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	458,570,138,667.30	460,841,635,873.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(83,253,400,028.74)	(78,497,970,826.67)
2.3.11	Эздийн өмчийн дүн	488,110,940,199.00	495,006,896,163.42
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	489,997,821,991.58	500,144,631,469.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	106,337,564,678.33	131,504,191,360.25
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	108,981,088,412.65	119,507,062,113.85
3	Нийт ашиг (алдагдал)	(2,643,523,734.32)	11,997,129,246.40
4	Түрээсийн орлого	-	-
5	Банкны дансны хадгаламжийн хүүгийн орлого	1,405,134,402.83	2,565,338,661.68
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		8,198,675,559.71
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,111,324,144.08	3,831,058,364.08
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,066,020,275.32	5,149,447,836.98
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		4,980,880,955.51
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(430,252.07)	258,464.19
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	969,124,240.70	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(7,447,039,762.26)	9,100,014,737.70
19	Орлогын татварын зардал	184,185,803.00	2,792,731,864.00
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(7,631,225,565.26)	6,307,282,873.70
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(7,631,225,565.26)	6,307,282,873.70
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(7,631,225,565.26)	6,307,282,873.70
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,920,778,280.94	450,591,592,284.17	(73,924,890,206.34)	489,462,357,925.07
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,920,778,280.94	450,591,592,284.17	(73,924,890,206.34)	489,462,357,925.07
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(7,631,225,565.26)	(7,631,225,565.26)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			7,978,546,383.13	(1,697,284,257.14)	6,281,262,125.99
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,454,286.80)			(1,454,286.80)
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	874,877,566.30	111,919,323,994.14	458,570,138,667.30	(83,253,400,028.74)	488,110,940,199.00
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
12	Залруулсан үлдэгдэл	874,877,566.30	111,919,323,994.14	458,570,138,667.30	(83,253,400,028.74)	488,110,940,199.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				6,307,282,873.70	6,307,282,873.70
14	Бусад дэлгэрэнгүй орлого					-
15	Өмчид гарсан өөрчлөлт			2,271,497,206.00	(1,551,853,671.63)	719,643,534.37
16	Зарласан ногдол ашиг					-
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(130,970,443.65)			(130,970,443.65)
18	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	874,877,566.30	111,788,353,550.49	460,841,635,873.30	(78,497,970,826.67)	495,006,896,163.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1.1	Мөнгөн орлогын дүн	123,089,538,595.35	158,344,353,335.45
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	120,364,579,453.82	146,907,705,236.81
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,495,800.00	12,615,500.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		4,128,883,626.5
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,723,463,341.53	7,295,148,972.11
1.2	Мөнгөн зарлагын дүн	101,162,250,538.32	120,379,926,545.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	40,159,350,269.85	51,024,202,794.97
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,155,901,321.95	15,155,176,689.01
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,866,698,603.87	6,915,639,620.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	18,498,379,016.14	20,019,181,811.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,903,515,711.91	4,178,394,931.91
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,491,779,815.49	16,519,353,203.42
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	26,287,532.39	158,858,112.70
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,060,338,266.72	6,409,119,380.93
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,927,288,057.03	37,964,426,790.11
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн	7,278,314,315.68	9,596,926,254.33
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,117,557,765.68	9,560,643,574.33
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	160,756,550.00	36,282,680.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,278,314,315.68)	(9,596,926,254.33)
3.1	Мөнгөн орлогын дүн	1,486,113.80	698,728.72
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад	1,486,113.80	698,728.72
3.2	Мөнгөн зарлагын дүн	1,916,365.87	440,264.53
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.5	Бусад	1,916,365.87	440,264.53
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(430,252.07)	258,464.19
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	14,648,543,489.28	28,367,758,999.97
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,714,477,613.05	59,363,021,102.33
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,363,021,102.33	87,730,780,102.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/ мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /илүү+ дутуу-/	Хувь
1	Нийт орлогын дүн	127,144,446.00	131,504,191.38	4,359,745.38	103.43
1.1	Цэвэр усны орлого	69,364,014.40	71,261,053.34	1,897,038.94	102.73
1.2	Бохир ус татан зайлуулсан орлого	54,642,696.60	56,932,419.14	2,289,722.54	104.19
1.3	Бусад орлого	3,137,735.00	3,310,718.90	172,983.90	105.51
2	Нийт зардал	132,855,258.30	128,487,568.30	(4,367,690.00)	96.71
2.1	Үндсэн ба нэмэгдэл цалин	56,584,344.70	55,791,648.60	(792,696.10)	98.60
2.2	Ажил олгогчоос эмнэлгийн хуудсаар олгосон	107,560.00	182,550.60	74,990.60	169.72
2.3	НДШ, ЭМД	7,526,701.60	8,179,414.80	652,713.20	108.67
2.4	Хоол, унаа	2,082,721.50	5,412,958.50	3,330,237.00	259.90
2.5	Сургалт	279,648.00	137,882.30	(141,765.70)	49.31
2.6	Тэтгэмж болон нийгмийн арга хэмжээ	655,104.50	429,456.70	(225,647.80)	65.56
2.7	Шагнал	44,910.00	36,300.40	(8,609.60)	80.83
2.8	Хлор, манганы сульфат, бодис, давс	2,646,341.00	1,830,297.10	(816,043.90)	69.16
2.9	Сэлбэг, багаж хэрэгсэл	3,472,468.40	2,597,034.00	(875,434.40)	74.79
2.10	Хангамжийн зардал	170,430.90	131,507.10	(38,923.80)	77.16
2.11	Түлээ, нүүрс	40,212.50	42,757.50	2,545.00	106.33
2.12	Шатахуун, тосолгоо	3,407,989.00	2,628,309.40	(779,679.60)	77.12
2.13	Цахилгаан	17,487,228.30	17,282,515.00	(204,713.30)	98.83
2.14	Дулаан, СӨХ	480,139.50	439,298.10	(40,841.40)	91.49
2.15	Ус	39,946.40	28,341.30	(11,605.10)	70.95
2.16	Харуул, хамгаалалт	336,905.90	295,207.90	(41,698.00)	87.62
2.17	Урсгал засвар, аваар, аваарын нөөц сан, тохижилт	1,818,412.10	1,097,363.50	(721,048.60)	60.35
2.18	Лагийн зардал	113,519.00	88,711.30	(24,807.70)	78.15
2.19	Бичиг хэрэг	94,632.20	67,922.50	(26,709.70)	71.78
2.20	Холбоо шуудан холбоо, хэвлэл захиалга	338,913.20	266,856.50	(72,056.70)	78.74
2.21	Томилолт	151,408.50	58,379.70	(93,028.80)	38.56
2.22	Зар сурталчилгаа, олон нийтийн зардал	201,218.00	148,639.20	(52,578.80)	73.87
2.23	Гадны үйлчилгээ	108,528.30	59,523.10	(49,005.20)	54.85
2.24	Банкны үйлчилгээ	10,711.50	6,864.50	(3,847.00)	64.09
2.25	Хөдөлмөр хамгаалал	1,504,080.00	1,124,258.50	(379,821.50)	74.75
2.26	Лабораторийн зардал	250,144.20	217,971.90	(32,172.30)	87.14
2.27	Төслийн зардал	479,115.70	248,047.70	(231,068.00)	51.77
2.28	УЗ-ын зардал	66,604.10	19,101.60	(47,502.50)	28.68
2.29	Найдваргүй авлагын зардал	74,047.50	-	(74,047.50)	-
2.30	Татвар, хураамж	1,388,945.50	1,376,108.70	(12,836.80)	99.08
2.31	Даатгал	71,988.60	75,180.40	3,191.80	104.43
2.33	Элэгдэл	30,820,337.70	28,187,159.90	(2,633,177.80)	91.46

3	Үйл ажиллагааны алдагдал	(5,710,812.30)	3,016,623.08	8,727,435.38	(52.82)
4	Үйл ажиллагааны орлогын нэг төгрөгт ногдох зардал	1.04	0.98	(0.07)	93.51
5	Үйл ажиллагааны бус орлого	3,311,203.90	10,764,272.68	7,453,068.78	325.09
6	Үйл ажиллагааны бус зардал	937,375.50	4,680,880.99	3,743,505.49	499.36
7	Нийт орлого	130,455,649.90	142,268,464.06	11,812,814.16	109.06
8	Нийт зардал	133,792,633.80	133,168,449.29	(624,184.51)	99.53
9	ОНТНЗ	1.03	0.94	(0.09)	91.27
10	Татвар төлөхийн өмнөх алдагдал	(3,336,983.90)	9,100,014.76	12,436,998.66	(272.70)
11	Орлогын татварын зардал		2,792,731.86	2,792,731.86	-
12	Тайлант үеийн цэвэр алдагдал	(3,336,983.90)	6,307,282.90	9,644,266.80	(189.01)
13	Авлага	11,186,108.40	9,885,814.59	(1,300,293.81)	88.38
14	Нийт өр төлбөр	1,886,881.80	5,137,735.31	3,250,853.51	272.29
15	Хөрөнгө оруулалт	14,146,800.00	9,596,926.25	(4,549,873.75)	67.84
16	Орон тоо	1,883.00	1,775.00	(108.00)	94.26

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг “Нийслэлийн хүн ам, албан байгууллагуудад стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангах, бохирдсон усыг зохих стандартын дагуу цэвэрлэж зайлуулах, хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийж хяналт тавих, эзэмшлийн инженерийн шугам, сүлжээ, тоноглолд технологийн шинэчлэлт хийх” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь “Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай, 100 хувийг орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Компанийн удирдлагыг НЗД-ын 2024 оны Б/159 дүгээр захирамжаар томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө...” гэж заасантай нийцэж байна.

НИТХ-ын тэргүүлэгчийн 2021 оны 2/81 тогтоолоор тус байгууллагын удирдах зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж, 2024 оны 24/17 дугаар, 1/2187 дугаар тогтоолуудаар тус тус удирдах зөвлөлийн гишүүдийг өөрчилж, шинэчлэн томилсон байна. Төлөөлөн удирдах зөвлөл тухайн онд 2 удаа хуралдаж, гишүүдэд нийт 15,180.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-д “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд “Өмч хамгаалах байнгын зөвлөл” нь байгууллагын өмчийн бүртгэл, ашиглалт хамгаалалтад анхаарч, хагас болон бүтэн жилээр тооллого хийж, хүн бүрийн ашиглаж байгаа өмч хөрөнгийг гамтай ашиглах, засвар үйлчилгээ хийх талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажилласан байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол;

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/229 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” А/211 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2024 оны “Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам” А/229 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2024 оны “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам” А/205 дугаар тушаал;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт хүчингүй болсон.

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ОНӨААТҮГ-ын “Үйл ажиллагааны хяналтын хэлтэс” нь тайлант онд байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулахдаа МУЗГ-ын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоол, НЗД-ын 2024 оны А/527 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”, байгууллагын даргын 2024 оны А/383 дугаар тушаалаар батлагдсан “Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баримтлан 59 ажил төлөвлөснөөс 90.5 хувийн биелэлттэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь газрын даргын 2020 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,146,809.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	59,363,021.1	87,730,780.1	28,367,759.0
Авлага	12,692,216.6	11,401,400.1	(1,290,816.6)
Урьдчилгаа	294,162.5	399,745.1	105,582.6
Бараа материал	15,061,291.4	13,018,966.8	(2,042,324.6)
Үндсэн хөрөнгө	402,587,130.3	387,593,739.4	(14,993,390.9)
Нийт хөрөнгө	489,997,822.0	500,144,631.5	10,146,809.5
Өр төлбөр	1,777,532.0	5,012,508.4	3,234,976.4
Урт хугацаат өр төлбөр	109,349.8	125,226.9	15,877.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	488,110,940.2	495,006,896.2	6,895,956.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	489,997,822.0	500,144,631.5	10,146,809.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр эздийн өмчийн данс байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь өмнөх оноос 28,367,759.0 мянган төгрөгөөр өссөн нь банкны харилцах дансны чөлөөт үлдэгдлийг хугацаатай хадгаламжид байршуулсны хүүгийн орлого, ХСУХАТАҮЗЗ-ийн 2023 оны 96 дугаар тогтоолоор 1 м.куб усны дундаж тариф болон төлбөрт үйлчилгээний тариф нэмэгдсэн, иргэдийн нийслэл хотод ирэх шилжилт хөдөлгөөнөөс хамааран хэрэглээний цэвэр усны болон бохир усны татан зайлуулах хэмжээ ихэссэнтэй тус тус холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл 11,401,400.1 мянган төгрөг болж 1,290,816.6 мянган төгрөгөөр буурсан нь айл өрх, албан байгууллагаас авах цэвэр, бохир усны төлбөр тооцооны дансны авлагаас 1,265,253.3 мянган төгрөгийг барагдуулж, НӨАТ-ын авлага 25,563.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна. Мөн ОСНААҮГ ОНӨУҮГ-ын хэрэглэгчийн үйлчилгээний төвүүд, тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн орон сууцны компаниудад түгээсэн усыг ус дулаан дамжуулах төвийн тоолуурын тухайн сарын эцсийн өдрийн заалтыг үндэслэж, бөөний үнээр тооцон, тухайн сарын борлуулалт гэж үздэг бөгөөд орлого нь дараа сард төлөгддөг учир авлагаар тайлагнадаг, энэ нь нийт авлагын 56.9 хувийг эзэлж байна. Насжилт өндөртэй 5 дээш жил болсон Чандмань Налайх ААТҮГ-ын 2,995,541.2 мянган төгрөгийн авлагад эвлэрлийн гэрээ байгуулж, гэрээнд заасан графикт дүнгийн дагуу жилд өгөх 132,000.00 мянган төгрөгийн төлөгдөөгүй бөгөөд нийт авлагын 28.1 хувийг эзэлж байна.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 399,745.1 мянган төгрөг болж 105,582.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь УБЦТС ХК-д цахилгааны илүү төлөлт 23,270.0 мянган төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид төлөх сэлбэг материалын урьдчилгааг 279,647.4 мянган төгрөгийн тооцоог хийж, Улаанбаатар хотын Яармагийн орчинд цэвэр усны шугам тавьсан, Сэлбэ коллекторын ажлуудын барьцааны авлага 408,500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

- Бараа материалын дансны үлдэгдэл 2,042,324.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 26,964,051.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 29,006,375.8 мянган төгрөгийн материал зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгө оруулалтаар их засварын болон шугам доторлосон нийт 9,198,627.5 мянган төгрөг, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 520,585.4 мянган төгрөг, хандив тусламжаар 117,394.0 мянган төгрөг, бараа материал данснаас 59,605.3 мянган төгрөг, Бүгд Найрамдах Австри улс болон МУЗГ хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн шугам доторлогооны хөрөнгө 1,897,112.3 мянган төгрөг, нийт 11,793,324.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, НӨХГ-ын даргын А/117 дугаар тушаалаар 2,703,211.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассан, тайлан оны 24,083,504.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 5,012,508.4 мянган төгрөг болж өмнөх оноос 3,234,976.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын өглөг 2,315,100.0 мянган төгрөг, шугам шинээр тавих ажлаас үүссэн 88 ажиллагсдын цалингийн өглөг 460,000.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын барьцааны өр төлбөрийн 819,800.0 мянган төгрөгөөр тус тус үүссэнтэй холбоотой байна.
- Урт хугацаат өр төлбөрийн данс нь 15,877.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 3 жилээс дээш хугацаатай хөрөнгө оруулалтын ажлуудыг барьцааны төлбөр үүссэн байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 495,006,896.2 мянган төгрөг болж 6,895,956.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

НӨХГ-ын даргатай 2024 оны 2024/02 дугаар бүхий “Ус сувгийн удирдах газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулан, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулан, ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 130,455,649.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 133,792,633.8 мянган төгрөгөөр, алдагдлыг 3,336,983.9 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 14,146,800.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Орлогын эх үүсвэр нь цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэр бохир усанд лабораторийн шинжилгээ хийх гэсэн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болон үйл ажиллагааны бус орлогоос бүрдэх бөгөөд тайлант хугацааны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг алдагдалтай баталсан нь төрөөс усны үнэ тарифыг тогтоодог бөгөөд ашгийн төлөө бус төрийн өмчийн байгууллагатай холбоотой юм.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 131,504,191.4 мянган төгрөг, үйл ажиллагааны бус 10,764,272.7 мянган төгрөг, нийт 142,268,464.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж,

нийт 133,168,449.3 мянган төгрөгийн зардал гарган, 9,100,014.8 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 131,504,191.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 4,359,745.1 мянган төгрөг буюу 3.4 хувиар давсан нь цэвэр усны хэрэглээ болон татан зайлуулсан бохир усны хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс өссөн, бусад орлого төлөвлөснөөс давж биелсэн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 128,487,568.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4,367,690.0 мянган төгрөг буюу 96.7 хувиар гүйцэтгэлтэй байна. Энэ нь батлагдсан орон тооноос 108 орон тоо дутуу ажилласан, материал, бодисын нэг бүрийн дундаж үнэ төлөвлөснөөс бага үнээр нийлүүлэгдсэн зэргээс шалтгаалан хлор, бодис, сэлбэг, шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлуудыг хэмнэсэн байна. Тухайлбал хлор, манганы сульфат, бодис, давс 816,043.9 мянган төгрөг, сэлбэг багаж хэрэгсэл 875,434.4 мянган төгрөг, шатахуун тосолгоо 779,679.6 мянган төгрөг, урсгал засвар, аваар, аваарын нөөц сан, тохижилт 721,048.6 мянган төгрөг, хөдөлмөр хамгаалал 379,821.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 110 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 9,596,926.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 6,307,282.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 9,644,266.8 мянган төгрөгөөр өсөж ашигтай ажилласан байгаа нь иргэд, ААНБ-ын цэвэр, бохир усны хэрэглээ төлөвлөснөөс нэмэгдсэн, үйл ажиллагааны бус орлогоос 10,764,272.7 мянган төгрөгийн орлого олж, 4,680,881.0 мянган төгрөгийн зардал гарч 6,083,391.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан зэрэг нөлөөлжээ.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь 2024 оны зорилтоор шинэ тоног төхөөрөмж худалдан авах, техник технологийн шинэчлэлт, барилга байгууламжийн их засварын ажилд 14,646,800.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсанаас 9,596,926.3 мянган төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.

Үүнээс шууд худалдан авалтын аргаар 321,254.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, 179,317.2 мянган төгрөгийн ажил үйлчилгээ, 252,122.3 мянган төгрөгийн засварын материал, 318,195.9 мянган төгрөгийн сэлбэг багаж хэрэгсэл, 115,264.0 мянган төгрөгийн бичиг хэрэг бусад хангамжийн материалын худалдан авалтыг 30 аж ахуйн нэгжтэй хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ОНӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулахаар анхан шатны баримтын бүрдэл хангасан баримтаар ажил гүйлгээ бүртгэх, насжилт өндөртэй авлага үлдэгдлийг барагдуулах, бүртгэлгүй үндсэн хөрөнгийг хэлэлцэн шийдвэрлүүлж, бүртгэлд тусгах, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд холбогдох хууль тогтоомж, зааврыг мөрдөж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Н.Баттогоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд, дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлангаа НТАГ-т 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 4/296 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг, суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 116,158,432.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,742,376.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан орон тооноос 108 орон тоо дутуу ажилласан, материал, бодисын нэг бүрийн дундаж үнэ төлөвлөснөөс бага үнээр нийлүүлэгдсэн зэргээс шалтгаалан хлор, бодис, сэлбэг, шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлуудыг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 171,774.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Тус газар нь шилэн дансны цахим хуудсанд 85,313,365.4 мянган төгрөгийн 735 мэдээллийг бүрэн байршуулсан байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХууль болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn сайтад ил тодоор байршуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3-д “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн баталж, дээд шатны байгууллагад цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх зөвлөмж өгөв.

2. Хугацаа хэтэрсэн 171,774.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, уг авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. /хэрэглэгчид үйлчлэх алба/ Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,058,357.6 мянган төгрөгийн 12 зөвлөмжийн хэрэгжилт 91.7 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,465.0	1	1,465.0	-	-	100.0
Албан шаардлага	7	921,225.7	6	921,225.7	1	-	87.7
Зөвлөмж	4	135,666.2	4	135,666.2	-	-	100.0
Нийт дүн	12	1,058,357.6	11	1,058,357.6	1	-	91.7

Хөрөнгийн тооллогыг бодитоор, үнэн зөв хийж, холбогдох хавсралт маягтуудыг бүрэн бүрдүүлж хийгээгүй зөрчлийг арилгаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

НИТХ 2024 оны 114 дүгээр тогтоол, НЗД 2024 оны А/1293 дугаар захирамжаар Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хийгдсэн Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн усан сан, насос станцын барилга, шугам сүлжээ зэрэг нийт 12,324,118.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж авах шийдвэр гарсныг туршилтын үйлдвэрлэл явуулж хэвийн үйл ажиллагааг хангасны дараа хүлээн авч ашиглах тайлбартайгаар НББ-д орлогоор бүртгээгүй, санхүүгийн тайланд тайлагнаагүй байгааг дараагийн аудитаар нарийвчлан үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,179,556.5 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Үйл ажиллагааны бус 8,498,675.5 мянган төгрөгийн орлогыг дэлгэрэнгүй тайланд дутуу илэрхийлсэн;
- Үйл ажиллагааны бус 4,680,881.0 мянган төгрөгийн зарлагыг дутуу илэрхийлсэн;

Аудитаар залруулагдаагүй нийт 1,491,446.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,324,503.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 166,942.2 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,491,446.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 250,930.3 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 138,350.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, засвар, ажил үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулсан байна.

Энэ нь УСНББОУС 29-т Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39-т Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-т голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээнд зөвшөөрсөн үйл ажиллагааны чиглэлтэй хуулийн этгээдээс үйлчилгээ аваагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд төрийн өмч хөрөнгөөр хэрэгжүүлсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд гэрээ байгуулж 1,186,153.5 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 38 дугаар зүйлийн 38.1-д “Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна” 10 дугаар зүйлийн 10.3-д “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын данс бүртгэлд орлогод авч бүртгээгүй 253 ширхэг (5,027,507.0 мянган төгрөг) үндсэн хөрөнгүүд байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дансанд бүртгэлд тусгаагүй хөрөнгийг орлого авч, санхүүгийн тайланд илэрхийлэх;

5.2.2 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт Борлуулалт болон бусад орлогуудын тооцоог татварын цахим и-баримтуудтай тулгахад татварын тайланд орлогыг 22,543.7 мянган төгрөг, НӨАТ-ыг 102.3 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн.

Энэ нь НББОУС 18 Орлого, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын цахим тайланд орлого, НӨАТ-ыг илүү тусгасан тооцоог дахин тулган баталгаажуулах, бүртгэлээр үе шатны тайланд тавих хяналтыг сайжруулах;

5.2.3 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: 1 ЖМС-гаас их хэмжээний 74,204.2 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч зарцуулж байгаа нь жижиг мөнгөн сан биш хөрөнгө бэлтгэх үйл ажиллагаа болсон байна.

Энэ нь УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-т голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн"; 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ЖМС-ийн зориулалтыг тодорхой болгох, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

Илрүүлэлт: 2 Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 70,092.0 мянган төгрөгийн ажил, гүйлгээ бүртгэсэн байна. /арга хэмжээний зарцуулалт тайлан, гэрээ дүгнэсэн актгүй/.

Энэ нь УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.4-т Голч, бодитой байх, санхүүгийн тайланд багтсан мэдээлэл ямар нэгэн нөлөөнд автаагүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 9 дүгээр сарын сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үйл ажиллагааны бус 8,498,675.5 мянган төгрөгийн орлогыг дэлгэрэнгүй тайланд дутуу илэрхийлсэн.	1	8,498,675.5	1	8,498,675.5	-	-	-	-	-	-	-	-
2	Үйл ажиллагааны бус 4,680,881.0 мянган төгрөгийн зарлагыг дутуу илэрхийлсэн.	1	4,680,881.0	1	4,680,881.0	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	2	13,179,556.5	2	13,179,556.5	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгууллагын хөрөнгийн тооллогоор тоологдсон данс бүртгэлд орлогод авч бүртгээгүй 43 ширхэг 5,027,507.0 мянган төгрөг, үнийн дүн тодорхойгүй 210 ширхэг хөрөнгүүд байна.	1	-										

2	Борлуулалт болон бусад орлогуудын тооцоог татварын цахим И баримтуудтай тулгахад орлогыг 22,543.7 мянган төгрөг, НӨАТ-ыг 102.3 мянган төгрөгөөр татварын тайланд тус тус илүү илэрхийлсэн.	1	22,646.0	-	-	-	-	-	1	22,646.0	-	-	-	-
3	Тайлант онд төрийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд гэрээ байгуулж бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.	1	1,186,153.5	-	-	1	1,186,153.5	-	-	-	-	-	-	-
4	Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас бараа материал худалдан авч, засвар, ажил үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулсан байна	1	138,350.5	-	-	1	138,350.5	-	-	-	-	-	-	-
5	ЖМС-гаас их хэмжээний хөрөнгө худалдан авч зарцуулж байгаа нь жижиг мөнгөн сан биш хөрөнгө бэлтгэх үйл ажиллагаа болсон байна.	1	74,204.2	-	-	-	-	-	1	74,204.2	-	-	-	-
6	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн. /арга хэмжээний зарцуулалт тайлан, гэрээ дүгнэсэн актгүй/	1	70,092.0	-	-	-	-	-	1	70,092.0	-	-	-	-
	Дүн	6	1,491,446.2	-	-	2	1,324,503.9	-	4	166,942.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

д/д	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/									
		Нийт зөрчил		Төлбөрийн акт				Үүнээс			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Хугацаа хэтэрсэн 171,774.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, уг авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. /ХҮА/	1	171,774.9					1	171,774.9	-	-
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn системд ил тодоор мэдээлээгүй байна.	1	-			-	-	-	-	1	0
	Дүн	2	171,774.9					1	171,774.9	1	0



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 44/А0260171

Улаанбаатар хот

НТАГ-2025/046/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хугацаа хэтэрсэн 171,774,900.00 (нэг зуун далан нэгэн сая долоон зуун далан дөрвөн мянга есөн зуун) төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, уг авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн авлага, өр төлбөрийг жилийн төсөөтөө бүрэн тусгаж барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, Эдийн засаг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ариунаа Ахлах нягтлан бодогч С.Даваасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТТОГОО

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 4 давхар

1433040179



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 412/А0260171

Улаанбаатар хот

НТАГ-2025/046/НА-СТА-ОНӨВГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагуудаас 138,350,500.00 (нэг зуун гучин найман сая гурван зуун тавин мянга таван зуун) төгрөгийн бараа материал худалдан авч, ажил үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөө болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлээс өөр төрлийн худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, Эдийн засаг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ариунаа Ахлах нягтлан бодогч С.Даваасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТТОГОО

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:

Я.АЛТАНЦЭЦЭГ

1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

112-34078



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 413/А0060171

Улаанбаатар хот

НТАГ-2025/046/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн өмч хөрөнгөөр хэрэгжүүлсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд гэрээ байгуулж 1,186,153,500.00 (нэг тэрбум нэг зуун наян зургаан сая нэг зуун тавин гурван мянга таван зуун) төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөөт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын дарга Ц.Төрхүү, Эдийн засаг санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ариунаа Ахлах нягтлан бодогч С.Даваасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТТОГОО

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

A blank sheet of white paper with horizontal dotted lines for writing.

Утас: +976 70007734

Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс